



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 4/38

Улаанбаатар хот

□ Уралдаан тэмцээнд оролцуулахаар
томилон ажиллуулах тухай □

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. 2018 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулагдах Ази Номхон далайн орнуудын Мастеруудын анхдугаар наадмын сагсан бөмбөгийн тэмцээнд тус хорооны Спортын хөгжлийн хэлтсийн дарга Сурмаажавын Саранцэцэг нь тамирчнаар оролцох тул ажлаас нь түр цалинтай чөлөө олгосугай.

2. Ази Номхон далайн орнуудын Мастеруудын анхдугаар наадамд оролцоход шаардагдах төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Тус тэмцээнд оролцоход шаардагдах зочид буудал, онгоцны тийзийн зардал болох нийт 5.899.550 /Таван сая найман зуун ерэн есөн мянга таван зуун тавин/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамирын уралдаан, тэмцээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.


4. Дээрх үйл ажиллагаанд томилогдон ажилласан талаарх тайланг ажлыг 7 хоногт багтаан тайлагнаж, судалж мэдсэн туршлагаа ажил үүрэгтээ нэвтрүүлж ажиллахыг Спортын хөгжлийн хэлтсийн дарга /С.Саранцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын
хорооны даргын 2018 оны *08 сарын*
20-ны өдрийн *А* дугаар тушаалын хавсралт



Томиллолт, онгоцны тийзийн зардлын төсөв

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төг/	Нийт зардал /төг/	
1.	Онгоцны билетийн үнэ /УБ– Бээжин – Каулалумпур – Пенанг, Пенанг – Каулалумпур - Бээжин - УБ /	1.955.550	1.955.550	
3.	Зочид буудал	8 х хоног x150\$=120\$x2465₮	2.958.000₮	
4.	Зам хоног	Хоол	8 х хоног x 50\$= 400\$ x2465₮	986.000₮
Дүн			5.899.550	